



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

XXXI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXI дүгээр хурал 2020 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 10:00 цагт Төрийн ордон дахь Шадар Сайдын ажлын өрөөнд 67 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 18 дугаар тушаалаар томилогдсон Шуурхай бүлгийн 2020 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 4-ний өдрүүдэд орон нутагт томилолтоор ажилласан тухай,

Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга,
дэд хурандаа Т.Мөнхдорж,

2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч,
Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэн

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагч
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

3. Хүнсний хангамж, нөөцийн өнөөгийн байдал, цаашид авах зарим арга хэмжээний тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
З.Мэндсайхан,

4. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн С.Наранцогт,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагч

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Гадаагийн иргэн, харьяатын газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Ууганбаяр,

Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Увс, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нарт:

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу түр хаасан хилийн Цагааннуур боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн нээх бэлтгэл ажлыг мэргэжлийн байгууллагууд үе шаттайгаар зохион байгуулах, хилийн Боршоо боомтыг түр хаасан хугацааг үргэлжлүүлэн сунгах;

1.2. Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу түр хаасан хилийн Цагааннуур боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс нээх бэлтгэл ажлын хүрээнд боомтын ажиллах цагийн хуваарийн саналыг холбогдох байгууллагуудтай тохиролцон асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулах;

1.3. Хилийн Цагааннуур, Боршоо боомтоор ОХУ-тай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр зөвхөн нефтийн бүтээгдэхүүнийг импортлогч байгууллагуудтай тохиролцож, улсын хилээр нэвтрүүлэх зохицуулалтын арга хэмжээг авах;

1.4. Хилийн Цагааннуур, Боршоо боомтоор орж ирсэн бараа бүтээгдэхүүнийг 3 хоногийн хугацаанд хадгалж, ариутгал халдваргүйжүүлэлт хийсний дараа иргэн, аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

1.5. ОХУ-аас ирж байгаа олон улсын ачаа тээврийн жолооч нараас халдвар илэрч байгаатай холбогдуулан хилийн Алтанбулаг, Цагааннуур, Боршоо боомтоор нэвтэрч буй жолооч нарыг коронавируст халдвар /Ковид-19/-ын PCR-ын шинжилгээг *172 цагийн дотор хийлгэсэн байх* үндэслэн улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

1.6. Баян-Өлгий аймаг дахь Цагааннуур, Увс аймаг дахь Боршоо, Дорнод аймаг дахь Эрээнцав, Сүхбаатар аймаг дахь Бичигт, Дорноговь аймаг дахь Замын-Үүд, Өмнөговь аймаг дахь Шивээхүрэн, Гашуунсухайт зэрэг Хилийн боомтуудад лабораторийн шинжилгээ хийх байрыг стандартын шаардлагад нийцүүлж, "Jene Xpert" аппаратаар хангах ажлыг шуурхай зохион байгуулах;

1.7. Цагааннуур боомт дахь Гаалийн байгууллагын лабораторийн барилгад коронавируст халдвар /КОВИД-19/-ын сорьц авах, шинжилгээ хийх лабораторийн өрөөнүүдийг төхөөрөмжлөн түр ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах;

1.8. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл маш өндөр, хүн амын дунд тархах эрсдэл өндөр байгаа тул бэлэн байдлыг хангуулах, эрсдэлийг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудыг оролцуулсан багийг хилийн боомт бүхий аймгуудад ажиллуулж, хамгаалалтын хувцас өмсөх, тайлах дараалал, бэлэн байдлын үед ажиллах горим гэх мэт сургалтыг биечлэн болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулж ажиллах;

1.9. Баян-Өлгийн аймгийн Мэргэжлийн хяналтын газарт туулах чадвар сайтай автомашин олгох, хийлийн боомтуудыг хэвийн ажиллуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

Хоёр. Зам тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой
комиссын гишүүн Д.Сумъяабазар,

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн С.Наранцогт,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Өнөрбаяр,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ,

МҮОНРТ-ийн дэд захирал Г.Гэрэл,

Аймгийн Засаг дарга нарт:

2.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор бүх шатны мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

2.2. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний стратеги, төлөвлөгөөг тодотгож, шинэчлэн батлуулах;

2.3. Улсын Онцгой комиссын 2020 оны 4 дүгээр албан даалгавар “Маскаа зүүцгээе, гараа угаая” аяныг чанартай зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлж, үйлчилгээний байгууллагын нэвтрэх хэсэгт иргэдийн халууныг тогтмол хэмжих, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг чанартай хийж, ажиллагсад, үйлчлүүлэгчдэд маск тогтмол зүүлгэж, маскгүй хүнд үйлчлэхгүй байх арга хэмжээг авах;

Гурав. Зам тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан,

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Өнөрбаяр,

Гаалийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

3.1. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулан, УИХ-аар хэлэлцүүлж батлуулах;

3.2. Хүн амын хүнсний хангамжийг бүрдүүлэлтэд шаардлагатай дараах нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг татвараас 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд чөлөөлөх:

-Төрөл бүрийн будаа /цагаан, шар, гурвалжин болон бусад/

-Ургамлын тос, элсэн чихэр, хүнсний улаан буудай, тарималын үр;

3.3. Нийслэл болон төв суурин газрын хүн амын 2021 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд малын мах бэлтгэн нөөцлөх ажлыг эрчимжүүлэх;

3.4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед хөл хорио тогтоох нөхцөл байдал үүссэн тохиолдолд Эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах талаар тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах;

3.5. Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

3.6. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийг тогтоох, нөөцийн хөдөлгөөнд дүн шинжилгээг тогтмол хийх, хүнсний нөөцийн тогтвортой байдлыг хангах;

3.7. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зохиомол хомсдол, үнийн хэт хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.8. 2021 оны хаврын тариалалтад шаардлагатай үрийн Улаан буудайн нөөц бүрдүүлж, нөөцлөх;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн газрын сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн С.Наранцогт,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Өнөрбаяр,
Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,
Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч,
Улсын онцгой комиссын гишүүн хурандаа Ж.Болд,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагч
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,
Дорноговь аймгийн Онцгой комисс дарга О.Батжаргал нарт:

4.1. Холбогдох байгууллагууд бэлэн байдлын болон хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан халдвар хамгааллын дэглэм, бусад арга хэмжээнүүдийг тодотгож, 2020 оны 11 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд салбаруудын бэлэн байдлаа шалгаж, төлөвлөгөөг дахин нягталж, бэлэн байдлыг хангуулахад шаардагдах төсөв, холбогдох бусад тооцоог гаргаж, 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Улсын онцгой комисст танилцуулах;

4.2. Хилийн боомтуудыг хүйтний улиралд ажиллах нөхцөл боломжоор хангах, хүйтний улиралд хамгаалалтын бүс байгуулан ажиллаж байгаа хөрш улстай дипломат шугамаар холбогдож туршлага судлан, өөрийн улсад нэвтрүүлэх, шаардлагатай хүний нөөц, төсөв, бусад тооцоог нэгтгэн боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

4.3. Замын-Үүд боомтод хамгаалалтын бүс байгуулах, өвлийн нөхцөлд ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах бусад орны туршлагыг судалж, шаардлагатай хөрөнгийн тооцоог гаргаж 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах;

4.4. ОХУ, БНХАУ-ын холбогдох байгууллагуудтай ачаа тээвэрлэлт, зорчигчийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцох талаар хамтран ажиллаж, боомтууд дахь хяналт шалгалт, халдвар хамгааллын дэглэмийг чангатгах талаар тодорхой ажил зохион байгуулах;

Тав. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Нямхүү нарт:


5.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангуулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллах;

5.2. ХӨСҮТ-ийн 60 ортой өргөтгөлийн барилгын ажлыг эрчимжүүлж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний дотор ашиглалтад оруулах:


Зургаа. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан, Баян-Өлгий аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга А.Гылымхан нарт:

6.1. Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангуулаагүй Нэгдсэн эмнэлгийн дарга, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА


Я.СОДБААТАР

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРГИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА



Т.МӨНХДОРЖ